

БҮС НУТГИЙН ИНТЕГРАЦИД ДУЛДУЙДАН ХӨГЖИХ НЬ МОНГОЛ УЛСЫН ИРЭЭДҮЙН АМЖИЛТЫН ТҮЛХҮҮР МӨН

С. Пауст*

Өнөөдрийн энэхүү симпозиумд уригдан оролцож, улмаар үг хэлж, өөрийн хувь нэмрээ оруулах завшаан тохиож байгаа нь миний хувьд том хүндэтгэл төдийгүй баярт үйл явдал болж байна. Энэ арга хэмжээг би хувьдаа туйлын чухал бөгөөд цаг үеэ олсон зүйл хэмээн үзэж байгаа учраас Монгол Улсын Гадаад харилцааны яаманд болон КАС-д энэхүү санаачилгыг гаргасных нь төлөө талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

Чухамдаа эдийн засгийн бодлогын шинжтэй миний илтгэл Зүүн хойт Азийн аюулгүй байдлын асуудлаар та бидний өрнүүлж буй яриа хэлцээнд яагаад ийм сүрхий нийцтэй байна вэ?

Эдийн засгийн солилцоо бол харилцан бие биенээ таньж мэдэх, ойлголцоход хувь нэмэр оруулж байдаг. Учир нь ийм солилцоо хэрэг дээрээ геостратегийн хамтын сонирхол болон харилцан хамаарлыг дэмжин лавшруулж, ингэснээрээ аюулгүй байдлын салбарын сөргөлдөөн аль ч талд нь ашиггүй бөгөөд тэр чанараараа сөргөлдөх магадлал буурахад дэм үзүүлдэг юм.

Тодорхой хэлэх юм бол, аливаа улс төрч худалдааны түншийнхээ эсрэг дайн эхэлбэл түүнээс авдаг эд бараа, санхүү мөнгө зэрэг нь хомсдох тул өөрийнхөө эдийн засгийг хохироон сүйрүүлэх, эсвэл үлэмж их уршиг учруулах болно гэдгийг мэдэх учраас ийм зүйлд нэн болгоомжтой ханддаг юм. Эдийн засгийн ийм хэлхээ холбоо, нэг ёсны харилцан хамаарлын тодорхой жишээ гэвэл, юуны өмнө өнөөгийн Европын Холбоо, бас тодорхой хэмжээгээр АНУ болон Хятадын харилцааг ч үүнд хамаатуулан авч үзэж болох агаад учир нь тэд аль хэдийн эдийн засаг, санхүүгийн нягт харилцаатай болсон байна.

* С. Пауст - Конрад Аденауэр сангийн төлөвлөлтийн хорооны гишүүн, доктор (Ph.D)

* Гадаад харилцааны яам, Конрад Аденауэр сангийн хамтран зохион байгуулсан симпозиумд тавьсан илтгэл

Энэ ойлголтыг Зүүн хойт Азийн бүс нутагт ч хамаатуулан авч үзэж болно гэдэгт би итгэлтэй байна. Би одоо Та бүхний өмнө „Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа бол Монголын ирээдүйн хөгжлийн түлхүүр мөн“ гэсэн сэдвээр илтгэл тавихдаа ч гэсэн энэ асуудлыг аюулгүй байдлын бодлогын хувьд тогтвортой байх Монгол Улсын зам мөрийн нэгэн хэсэг хэмээн харж байна.

Монгол Улс эдүгээ хүртэл Зүүн Азийн бусад орнуудтай худалдаа, хөрөнгө оруулалт ба дэд бүтэц гэх зэрэг бүс нутгийн интеграцийн асуудлаар нягт хамтран ажиллах тал дээр болгоомжилсон байдалтай буюу хойш суун хандаж ирсэн юм.

Гэтэл хэдэн жилийн өмнөөс уг бүс нутагт шинэ интеграцийн сонирхолтой эхлэл тавигдаж байна. Жишээ нь Ши Жиньпиний саяхан дэвшүүлсэн торгон замын санаачилга, эсвэл түүнээс өмнө байгуулагдсан Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (ТАБНЭЗХА), Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) зэргийг эрчимтэй урагшлуулах үйл явц өрнөж байна.

ШХАБ-ын хувьд Монгол Улс зөвхөн ажиглагчийн статустай байгаа бол ТАБНЭЗХА -д бол бусдад төдийлөн анзаарагддаггүй гишүүн улс төдий юм. Улс төрийн ажиглагчид энэ байдлыг дүгнэхдээ, Монгол Улсын энэхүү онц хянамгай байр суурь нь Орос, Хятад хэмээх хоёр хөршөөсөө, юуны өмнө Хятадаас болгоомжилдогтой нь холбон үздэг бөгөөд ялангуяа ТАБНЭЗХА болон ШХАБ-д БНХАУ тэргүүлэх байр суурьтай байдагтай холбон тайлбарладаг.

Түүнчлэн бас нэг цаад шалтгаан нь бол Монгол Улс ардчиллыг баримталсан итгэл үнэмшилтэй байхад дээрх хоёр байгууллагын гишүүн орнуудын ихэнх нь автократ засаглалын системтэй байгаад орших буй заа.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын өмнө тулгарч буй сорил нэн ойлгомжтой. Учир нь энэ орон Орос, Хятадын хооронд жийргэвч улсын байдалтай байдаг төдийгүй юуны түрүүнд эдийн засгийн хэлхээ холбооны хувьд хөрш орнуудаасаа, ялангуяа Хятадаас үлэмж хамааралтай байгаа юм. Үүнээс гадна бас дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн бууралт болон гадаадын хөрөнгө оруулагчдын тоо багассантай холбоотойгоор Монголын эдийн засгийн эрчимтэй өсөлт зогсох магадлалтай байна. Ингэснээр Монгол Улс эдийн засгийн маш ноцтой асуудалтай тулгарахад хүрээд байгаа учраас миний энэхүү илтгэлийн гол санаа бол зөвхөн тууштай бөгөөд хэм хэмжээг нь хамгийн оновчтой зөв тааруулсан бүс нутгийн интеграцчилал л монголын эдийн засгийг тогтворжуулж, нааштай хандлага руу оруулах учиртай гэсэн бодол юм.

Зөвхөн Европын Холбоо ч биш, харин маш амжилттай хөгжиж байгаа Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН) бол хэрвээ зөв ажиллавал өсөлтийг, баялгийг болон хөгжлийг хөхиүлэн дэмжих нөлөөлөл бүхий бүс нутгийн интеграцийн тод жишээ юм. Учир нь ийм интеграц бол оролцогч талууд зах зээлдээ харилцан нэвтрэх боломжийг нь нэмэгдүүлж, аж үйлдвэрийн болон эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэлийг эрчимжүүлж, санхүүгийн ба хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэрийг нээж өгдөг. Үүгээрээ уг бүс нутгийн орнуудын хөгжлийн янз бүрийн хурдцыг уялдуулахад тус дөхөм болдог юм.

Энэ бүхэн Монгол Улсын хувьд юу гэсэн үг вэ? Чухамдаа энэ орон олон чиглэлээр нэгэн зэрэг интеграцид орох маш их нөөц бололцоотой юм. Үүний өмнө дурдсанчлан түүний “жийрэг улсын” байдалтай байрлал, түүнээс гадна шууд хиллэдэг гуравдах хөршгүй болон далайд гарцгүй нөхцөл байдлыг нь харин ч бүр боломж бололцоо хэмээн авч үзэж болно.

Монгол Улсын эдийн засагт ойрын ирээдүйд шийдвэрлэх чухал нөлөөтэй гэж үзэхүйц түүхий эдээ борлуулахын тулд амархан хүрч болохуйц зах зээл хэрэгтэй байгаа. Монголын түүхий эдийн баялгийг худалдан авах сонирхол зөвхөн АНУ болон ЕХ-гоор хязгаарлагдахгүй. Борлуулалтын хамгийн сонирхолтой зах зээл гэвэл ирэх жилүүдэд эдийн засгийн хөгжлийн өсөлтөөр АНУ болон ЕХ-ноос ч илүү байх өндөр магадлалтай, бас Монголын хувьд “булан тойроод” л хүрчихүйц, зам тээврийн хувьд ойр дөт орших Япон, Өмнөд Солонгос, АСЕАН-ы орнууд болон ялангуяа Хятад Улсыг хамарсан бүс нутаг юм.

Үүнээс гадна Монгол Улс юуны өмнө хөдөө аж ахуйнхаа боломжоор, ялангуяа мал аж ахуйн бүтээгдэхүүн болох мах, сүүний үйлдвэрлэлээ чиглэсэн зорилготойгоор хөгжүүлэх замаар зөвхөн ашигт малтмалдаа дулдуйдсан эдийн засгаа цаашид боловсронгуй болгож, тууштай өргөжүүлэн баяжуулах боломжтой. Хэрвээ Монгол Улс эрүүл мэндийн болон мал эмнэлгийн стандартаа сайжруулахын зэрэгцээ үйлдвэрлэл, тээвэрлэлтийн болон дэд бүтцийн боломжоо нэмэгдүүлж чадвал энэ бүс нутагт эрэлт хэрэгцээ маш их байгаа.

Хөдөө аж ахуй нь ч бай, эсвэл аажуу удаан ч гэсэн эрхбиш урагшлан хөгжиж байгаа дахин боловсруулах аж үйлдвэрлэл нь ч бай, ерөнхийдөө дотоод зах зээлийнхээ 3 сая арай хүрэхгүй хэрэглэгчдэд чиглэсэн байдлаа удахгүй давж гарах болно. Гэтэл Монголын эдийн засагт нэн хэрэгтэй зах зээлээ өргөжүүлэх боломж нь хаа хол байгаа АНУ болон ЕХ-ноос түлхүү хамаарах эсэх нь харьцангуй

эргэлзээтэй. Харин эдийн засгийн интеграцаар дамжуулан ойрхон байгаа томоохон зах зээл рүү орох болон өөрийнхөө ойр орчмын бүс нутагт их хэмжээний борлуулалтын боломж буй болгохыг чармайх нь илүү утга учиртай байх.

Монгол болон Зүүн Азийн бусад орнуудын хооронд зарим түүхий эдийн худалдааны гаалийн тариф бэлхнээ бага байгаа ч гэсэн чөлөөт худалдааны хэлэлцээрийг ашиглах аваас цаашлаа зөвхөн гаалийн тогторыг бууруулахаас гадна бас худалдаан дахь тарифын бус бэрхшээлүүдийг арилгаж болно. Харамсалтай нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон мөртлөө Монгол Улс одоогоор ямар ч улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаагүй байгаа цорын ганц улс бөгөөд энэ нь юуны өмнө Зүүн Азид улам бүр нэмэгдэж буй чөлөөт худалдааны олон улсын хэлэлцээрүүдийн "гурилтай шөл" буюу „Noodle Bowl“ гэгчийн дундах нэгэн урам хугармаар онцгойрол болон харагдаж байгаа нь гайхмаар юм.

Бас нэг өөр аспект нь: Монгол Улс бол, өмнө бэлхнээ дурдсанчилан газар зүйн хувьд Зүүн Хойт Азийн төвд байрлалтай, өөрөөр хэлбэл зүрхэнд нь оршдог бөгөөд үүгээрээ Оросын түүхий эдийн болон эрчим хүчний зах зээлийг Хятадын аж үйлдвэрлэлээс өргөн хэмжээгээр зааглахаас гадна (Хятад улс бол Оросын хувьд эдүгээ худалдааны хамгийн том түнш болон хувираад байгаа) бас Хятадын аж үйлдвэржсэн зүүн хойд мужууд болон харьцангуй бага нээгдсэн баруун хойд мужуудын хооронд газар зүйн хувьд зааглах шаантаг мэт байрлалтай юм.

Орос, Хятадын бараа солилцооны ихэнхи хэсэг нь одоогоор Монголын газар нутгаар дамжин хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь наанадаж монголын тааруухан хөгжсөн автомашины болон төмөр замын дэд бүтцийн дамжуулах боломжоос хамааралтай байгаа юм. Үүнийг Ши Жиньпиний Торгон замын санаачилгын ирээдүйтэй холбон авч үзэх юм бол Монголын хувьд Зүүн Азийн Умард-Өмнөт ба Дорнод-Өрнөдийн чиглэлийн зам тээвэр, болон тээвэрлэлт, дамжуулах хоолойн зангилаа улс болж хөгжих, улмаар ямар их ашиг орлого олох нөөц боломж нээгдэж байгааг төсөөлөхөд түвэггүй юм.

Мэдээж хэрэг, одоохондоо Монгол Улсад тээврийн болон эрчим хүчний дэд бүтцийн шинэчлэл болон өргөтгөлд хэрэгцээтэй хөрөнгө дутагдаж байгаа. Гэхдээ хятадын болон оросын санхүүгийн хүч чадлыг бодолцож үзэх аваас энэ нь чухамдаа "хаалганых нь үүдэнд" бэлэн байгаа бөгөөд үүнийг зөвхөн бүс нутгийн интеграцийг өлөөхүйц зам тээврийн болон дамжин өнгөрүүлэх дэд бүтцийн санаачилгаар

дамжуулан идэвхжүүлэхэд л хангалттай юм. Энэ бүхэн нь эцсийн дүндээ бүс нутгийн интеграц л Монголын ирээдүйд нэн чухал бодит боломжуудыг буй болгоно гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Харин интеграцийн ямар хэлбэрийг Монгол Улс тэргүүн эгнээнд хэрэгжүүлэх ёстой вэ гэдэг асуултад хариу олоход нэлээд эрсдэлтэй байгаа. Эдийн засгийн чухал түншүүдтэйгээ хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээрийн сүлжээ байгуулах гэж чармайх нь Монгол Улсын хувьд тийм ч зөвлөөд баймаар зүйл биш. Учир нь Монгол Улс зөвхөн ашигт малтмал дээрээ суурилсан, жижигхэн бөгөөд сулхан хөгжсөн эдийн засагтай орны хувьд БНХАУ, Япон гэх мэт хүчирхэг эдийн засагтай улсуудтай яриа хэлэлцээ хийхэд анхнаасаа л сул дорой байр суурьтай байх магадлалтай. Энэ утгаар эргэцүүлж үзвэл, ТАБНЭЗХА болон ШХАБ зэрэг бүс нутгийн эвслүүд хамгийн боломжтой буюу дөхөмтэй гэхээр юм. Гэвч энэ хоёр байгууллагын хувьд монголчууд болгоомжлонгуй хандсаар ирсэн нь дээр дурдсанчилан эдгээр байгууллага ардчиллын хомсдолтой гэх бодол санаанаас шалтгаалсан монголчуудын эргэлзээтэй холбоотой төдийгүй уг эвслүүдэд монголын өмнөд их хөрш БНХАУ-ын нөлөөлөл үлэмж хүчтэйгээс гадна ШХАБ-д бас ОХУ-ын нөлөө давамгайлах хандлагатай байгаа гэж үздэгээс нь үүдэлтэй юм. Үүнээс гадна энэхүү хоёр эвслийн загваруудын өнөөг хүртэлх интеграцийн ахиц дэвшил нь үнэндээ явцуу, хязгаарлагдмал гэхээр байгаагаас гадна интеграцийн эрчим нь бараг зогсонги байдалтай байна.

Монголын талаас ихэвчлэн Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгуулга (АПЕК), Транс-Номхон далайн түншлэл (ТПП)-ийн хувьд найдвар төрүүлмээр мэдээнүүд ирдэг юм. Гэвч хоёр тивийг хамарсан эвслийн оролдлогуудын интеграцийн нөлөө одоо хүртэл тун чамлалттай байгаа бөгөөд ойрын үед өөрчлөгдөх магадлал маш бага байна. Тэгээд ч ТПП-д Хятад, Солонгос болон Орос байхгүй. Үүнээс гадна АПЕК/ТПП-ийн бусад гишүүн орнуудтай харьцуулбал Номхон далайд гарцгүй, буурай хөгжилтэй Монголын хувьд гишүүнчлэлийн магадлал эргэлзээтэй.

Сүүлийн үед Зүүн хойд Азийн чөлөөт худалдааны нийгэмлэг буюу NEAFTA улс төрийн яриа хөөрөөний сэдэв болсоор байгаа бөгөөд энэ томьёолол янз янзын хувилбартайгаар яригдаж байна. Япон-Өмнөд Солонгос-АНУ гэсэн хувилбараас гадна Япон-Өмнөд Солонгос-Хятад гэсэн хувилбар байгаа бөгөөд сүүлийн үед хятадын талаас санаачлан дэвшүүлсэн Хятад-Орос-Хойд ба Өмнөд Солонгос, Монгол гэсэн хувилбар илүү өргөн хамааралтай байна.

Эхний хоёр хувилбар нь хоорондоо ойролцоо буюу хүчирхэг

эдийн засаг бүхий бөгөөд аж үйлдвэрийн хувьд өндөр хөгжсөн орнууд багтаж буй. Эдгээр хувилбарт хөдөө аж ахуй зонхилсон, түүхий эдлээ тулгуурласан эдийн засагтай хөгжиж буй орон болох Монголын орон зай тун бага учраас тохиромж муутай. Түүнээс гадна хамгийн эхний хувилбарт Монголын эдийн засгийн гол түнш гэгддэг болсон Хятад улс ороогүй байгаа нь энэ хувилбарыг үнэгүйдүүлж байгаа хэрэг.

Харин хоёрдугаар хувилбар нь газар нутгийн маргаантай асуудлаас эхлээд ашиг сонирхлын хувьд зөрөлдөөнтэй зүйл ихтэйгээс болоод урагшлахдаа маш хойрго байх магадлалтай юм. Гуравдахь хувилбар ч мөн иймэрхүү бэрхшээлтэй тулгарах бөгөөд Хойд Солонгосыг үүнд оруулан авч үзэхээр тооцвол хэрэгжих боломжийг нь бас давхар хүндрүүлж болох талтай.

Тэгээд ч одоогоор НЕАФТА-ийн интеграцийн хурдыг угтуулан таамаглахад хэцүү байгаа.

Их түмэн санаачилга бол газар зүйн талаасаа явцуухан бөгөөд Хойд Солонгос гишүүн нь учраас чиглүүлэн зохицуулахад амаргүй. Тэгээд ч өнөөг хүртэлх интеграцийн ахиц дэвшил нь хомсхон байна. Ингэхээр Азийн аль бүс нутгийн эвсэл хамгийн ахицтай байгааг эргэцүүлэн харвал, шууд АСЕАН буюу Зүүн өмнөт Азийн 10 орныг багтаасан холбоон дээр л анхаарал аяндаа тогтох болно. Дэлхийн хэмжээнд аваад үзсэн ч (одоохондоо) хөгжиж буй орнуудын хүрээнд хамгийн сайн үйл ажиллагаатай гэхүйц интеграцийн эхлэл бол энэ л байна.

АСЕАН бол 2015 онд барааны, үйлчилгээний, хөрөнгө оруулалтын, хөрөнгийн болон ажиллах хүчний чөлөөт солилцоо бүхий „ASEAN Economic Community“ (АЕС) буюу эдийн засгийн нэгдмэл бүс байгуулахаар төлөвлөж байгаагаас гадна хил дамнасан зам, тээврийн болон эрчим хүчний “Их Меконгийн дэд бүс” зэрэг өргөн далайцтай төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн санхүү, валютын интеграцын нэлээд зүгширч буй эхлэл болох Chiang Mai Initiative Multilateralisation (СМІМ) гэх зэрэг нь валютын ханшийн ноцтой хэлбэлзлээс урьдчилан сэргийлэх хяналтын механизм мөний зэрэгцээ их хэмжээний хөрөнгийн нөөцийг бүрдүүлсэн санхүүгийн ба валютын интеграцийн дэвшилтэй хандлага учраас энэ нь яваандаа Азийн валютын сан болон хөгжих ирээдүйтэй юм. Энэ тал дээр АСЕАН-ы “өргөтгөл” буюу АСЕАН+3 гэх арга хэмжээний хүрээнд БНХАУ, Өмнөд Солонгос болон Япон Улс нааштай хандаж байгаагийн гадна чөлөөт худалдааны хэлэлцээрийн сүлжээгээрээ дамжуулан дэлхийн хамгийн том чөлөөт

худалдааны бүс болох тууштай зам дээрээ байна. Ингэснээр энэ эвсэл Зүүн Азийн түлхүүр байгууллага болон хөгжих боломжтой.

АСЕАН+3 нь үр дүнтэй интеграцын үйл явцын катализатор болохоо харуулсны зэрэгцээ бүс нутгийн улс төрийн маргааныг зохицуулах (одоохондоо бүрэн ашиглаагүй) потенциалтай юм. Жишээ нь Монгол шиг жижиг орны сул дорой гэгдэх байр суурь Хятад улс шиг их хөршийнхөө өмнө ямаршуухан байхыг аваад үзье. Тэгвэл энэ асуудал дээр ч АСЕАН+3 механизм нь тухайн улс өөрийн сонирхолоо хамгаалахад тогтвортой түшиг тулгуур болох боломжтой.(Энэ нь тухайлбал Филиппин Улс болон БНХАУ-ын хоорондох газар нутгийн маргаан дээр тод харагдсан). Энэ бүхэн бол АСЕАН+3 загвар Монголын хувьд бүс нутгийн интеграцийн үүднээс илүү оновчтой байж болохыг харуулж буй үнэмшилтэй нотолгоо юм.

Монгол Улс газар зүйн байршлаараа бол Өмнөд Азийн орон биш гэдэгтэй маргах аргагүй. Үүнээс гадна дээр дурдсанчилан АСЕАН-ы интеграц нэлээд их урагшлан хөгжчихсөн байгаа. Гэлээ ч гэсэн Монгол Улсын хувьд Зүүн Өмнөд Азийн АСЕАН+ томьёоллын дараачийн орон болж нэгдэх боломжийг сүвэгчлэн хайж, нухацтай авч үзэх, өөрөөр хэлбэл, АСЕАН+3 томьёоллыг өргөтгөн АСЕАН+4 болгохыг хичээгүүштэй. Үүний тулд Монгол Улс АСЕАН+3-ын бэлхнээ хэрэгжүүлсэн интеграцийн дэвшлийг нөхөж гүйцэх буюу түүнд элсэн ороход интеграцын гэрээгээр тавигдах шаардлага, шалгууруудыг аль болох хангахад ирээдүйн бодлогоо чиглүүлэн ажиллах хэрэгтэй. Энэ үүднээс Монгол Улс одоогийнхоосоо илүү тууштайгаар өөрийн эдийн засгийн үйл ажиллагаа болон гадаадын хөрөнгө оруулалтын орчинг үлэмж сайжруулах, ялангуяа хууль эрх зүйн тогтвортой байдлыг хангах, хүнд суртлыг арилгах, худалдааны хөнгөлөлт, эрчим хүчний хангалт, зам тээврийн дэд бүтэц зэргийг сайжруулах болон иргэдийнхээ боловсролыг дээшлүүлэхэд гойд анхаарах шаардлагатай.

Эдгээрээс үүдэн дараах дүгнэлт хийж болох юм. Үүнд: Монгол Улс хөгжлийн олон тооны бэрхшээлүүдтэй тулгарч байгаа ч асар их амжилтанд хүрэх боломжтой нь эргэлзээгүй байна. Тэгэхдээ үүнийг хэрэгжүүлэхийн тулд Зүүн Ази руу хандсан тов тодорхой, чиглэсэн зорилго бүхий эдийн засгийн интеграцийн ачаар өөрийн үндэсний хөгжлийн хомсдлыг даван гарч засах, улмаар өрсөлдөх чалвараа сайжруулах хэрэгтэй. Харин маш их хурдацтай сүлжээлэн хөгжиж байгаа Зүүн Азийн интеграцийн газрын зураг дээр сул дорой хөгжилтэй “цагаан толбо” болон хоцрох ёсгүй.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.